



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 17/2025

Сүхбаатар сум

Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн
албаны Санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2025 оны дугаар 05 сарын 23-ны өдрийн 17 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн албаны санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын Санхүү хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Мөнхзул 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн албаны 2023, 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн албан нь улсын бүртгэлийн 3741222 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131052001 дугаартай үндсэн данс, 100131052401 дугаартай нэмэлт дансыг ашиглаж байна.

1.5. Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн албаны төсвийн орлого, тайлан, төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Захирагчийн албаны Захирагч Б.Отгонбаяр, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Л.Баасансүрэн нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

1.6. Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн алба нь улс төрийн албан тушаалтан 1, төрийн захиргааны албан хаагч 1, төрийн үйлчилгээний 8 нийт 10 албан хаагч үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн албаны санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2023 онд орон нутгийн төсвөөс 224.695.4 мянган төгрөгөөр 2024 онд 387,672.3 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсанаас 2023 онд 208,686.2 мянган төгрөгийг буюу 92.9 хувийг, 2024 онд 382,561.7 мянган төгрөгийг буюу 98.7 хувийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 1

/мян.төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 онд			2024 онд		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	224,695.4	208,686.2	16,009.2	387,672.3	382,561.7	5,110.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,695.4	208,686.2	16,009.2	387,672.3	382,561.7	5,110.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,860.4	201,851.2	15,009.2	381,072.3	376,005.9	5,066.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,076.5	138,670.9	8,405.6	258,276.6	257,809.6	467.0
210101	Үндсэн цалин	96,670.0	104,023.4	-7,353.4	121,777.5	159,433.4	-37,655.9
210102	Нэмэгдэл	50,406.5	29,658.4	20,748.1	136,499.1	94,103.8	42,395.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
210104	Урамшуулал	0.0	4,989.1	-4,989.1	0.0	4,272.4	-4,272.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,384.6	17,285.2	1,099.4	32,284.5	32,284.5	0.0
210201	Тэтгэврийн даатгал	12,501.5	11,913.2	588.3	21,953.4	21,953.4	0.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,470.8	1,401.6	69.2	2,582.8	2,582.8	0.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,176.6	1,121.4	55.2	6,456.9	6,456.9	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	294.2	252.5	41.7	1,291.4	1,291.4	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,941.5	2,596.6	344.9	0.0	0.0	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,176.8	24,376.8	1,800.0	59,112.9	56,783.5	2,329.4
210301	Гэрэл, цахилгаан	4,875.0	4,875.0	0.0	8,783.5	8,783.5	0.0
210302	Түлш, халаалт	21,301.8	19,501.8	1,800.0	48,000.0	48,000.0	0.0
210303	Цэвэр, бохир ус	0.0	0.0	0.0	2,329.4	0.0	2,329.4
2104	Хангамж, бараа материалын зардал	7,715.4	6,104.0	1,611.4	10,639.5	10,326.7	312.8
210401	Бичиг хэрэг	1,686.9	1,193.6	493.3	1,779.5	2,054.4	-274.9
210402	Тээвэр, шатахуун	3,422.5	3,422.3	0.2	5,797.4	5,698.2	99.2

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,477.9	360.0	1,117.9	1,528.5	1,040.0	488.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,128.1	1,128.1	0.0	1,534.1	1,534.1	0.0
2105	Нормативт зардал	304.0	0.0	304.0	647.3	479.5	167.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	304.0	0.0	304.0	647.3	479.5	167.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,774.2	4,000.0	774.2	2,067.4	2,064.2	3.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	774.2	0.0	774.2	1,139.2	1,139.2	0.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.0	0.0	0.0	928.2	925.0	3.2
210604	Урсгал засвар	4,000.0	4,000.0	0.0	0.0	0.0	0.0
2107	Томилолт, зочны зардал	1,148.4	1,148.4	0.0	1,048.4	949.0	99.4
210702	Дотоод албан томилолт	1,148.4	1,148.4	0.0	1,048.4	949.0	99.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,254.2	6,265.9	988.3	12,609.8	11,198.9	1,410.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,882.0	6,265.9	616.1	12,052.6	11,198.9	853.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60.1	0.0	60.1	60.1	0.0	60.1
210803	Даатгалын үйлчилгээ	122.3	0.0	122.3	122.3	0.0	122.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	126.6	0.0	126.6	136.0	0.0	136.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.0	0.0	0.0	49.0	0.0	49.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	63.2	0.0	63.2	63.2	0.0	63.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	0.0	0.0	126.6	0.0	126.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,026.3	4,000.0	26.3	4,385.9	4,110.0	275.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000.0	4,000.0	0.0	4,000.0	3,860.0	140.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26.3	0.0	26.3	385.9	250.0	135.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,835.0	6,835.0	1,000.0	6,600.0	6,555.8	44.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,835.0	6,835.0	1,000.0	6,600.0	6,555.8	44.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,835.0	6,835.0	0.0	0.0	0.0	0.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	0.0	0.0	6,600.0	6,555.8	44.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.0	0.0	1,000.0	0.0	0.0	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	224,695.4	208,686.2	16,009.2	387,672.3	382,561.7	5,110.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	216,495.5	208,686.2	7,809.3	387,672.3	382,561.7	5,110.6

320001	Орон нутгийн төсвөөс	216,495.5	208,686.2	7,809.3	387,672.3	382,561.7	5,110.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,199.9	0.0	8,199.9	0.0	0.0	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	8,199.9	0.0	8,199.9	0.0	0.0	0.0

Төсвийн гүйцэтгэлийн судалгаанаас зарцуулалтыг зардлын ангилал бүрээр шалгаж дүгнэхэд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** нийт төсвийн 2023 онд 147,076.5 мянган төгрөг 2024 онд 258,276.6 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөснөөс 2023 онд 138,670.9 мянган төгрөгийг зарцуулж 8,405.6 мянган төгрөгийг хэмнэж 2024 онд 257,809.6 мянган төгрөгийг зарцуулж 467.0 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь зарим сард орон тоо гүйцэд биш ажилласнаас шалтгаалсан байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:** 2023 онд 26,176.8 мянган төгрөг батлагдсанаас гэрэл цахилгааны зардал 4,875.0 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 19,501.8 мянган төгрөг зарцуулж, 1,800.0 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд 59,112.9 мянган төгрөг батлагдсанаас гэрэл цахилгааны зардал 8,783.5 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 48,000.0 мянган төгрөг зарцуулж, 2,329.4 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.
- Хангамж бараа материалын зардал:** 2023 онд хангамж, бараа материалын зардалд 7,715.4 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 1,193.6 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 3,422.3 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 360.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 1,128.1 мянган төгрөг зарцуулж 1,611.4 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд хангамж, бараа материалын зардалд 10,639.5 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 2,054.4 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 5,698.2 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 1,040.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 1,534.1 мянган төгрөг зарцуулж 312.8 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.
- Нормативт зардал:** 2023 онд 304.0 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэл гараагүй, 304.0 мянган төгрөг хэмнэж, 2024 онд 647.3 мянган төгрөг батлагдаж 479.5 мянган төгрөг зарцуулж 167.8 мянган төгрөг хэмнэлттэй байна.
- Эд хогшил, урсгал засварын зардал:** 2023 онд 4,774.2 мянган төгрөг батлагдаж урсгал засварын зардалд 4,000.0 мянган төгрөг зарцуулж, 774.2 мянган төгрөг хэмнэж, 2024 онд 2,067.4 мянган төгрөг батлагдаж, багаж техник хэрэгслийн зардалд 1,139.2 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 925.0 мянган төгрөг зарцуулж, 3.2 мянган төгрөгийг хэмнэжээ
- Томилолтын зардал:** 2023 онд 1,148.4 мянган төгрөг батлагдаж 100 хувь зарцуулж, 2024 онд 1,048.4 мянган төгрөг батлагдаж 949.0 мянган төгрөг зарцуулж 99.4 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2023 онд 7,254.2 мянган төгрөг батлагдсанаас 6,265.9 мянган төгрөг зарцуулж 988.3 мянган төгрөг хэмнэсэн, 2024 онд 12,609.8 мянган төгрөг батлагдаж 11,198.9 мянган төгрөг зарцуулж 1,410.9 мянган төгрөг хэмнэсэн байна.

8. **Бусад зардал:** 2023 онд 4,026.3 мянган төгрөг батлагдаж 4,000.0 мянган төгрөг зарцуулж 26.3 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд 4,385.9 мянган төгрөг батлагдаж бараа үйлчилгээний бусад зардалд 4,110.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 250.0 мянган төгрөг зарцуулж, 275.9 мянган төгрөг хэмнэсэн байна.
9. **Урсгал шилжүүлгийн зардал:** 2023 онд 7,835.0 мянган төгрөг батлагдаж 6,835.0 мянган төгрөг зарцуулж, 1,000.0 мянган төгрөг хэмнэсэн, 2024 онд Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 6,600.0 мянган төгрөг батлагдаж 6,555.8 мянган төгрөг зарцуулж, 44.2 мянган төгрөг хэмнэжээ.

2.4 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн алба нь 2023, 2024 онуудад төсвийн хөрөнгөөр ажил үйлчилгээ, бараа материал шууд худалдан авах босго үнээс давсан томоохон худалдан авалт хийгдээгүй байна.

2.5. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2023,2024 онуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитаар бие даасан дүгнэлт гараагүй түүвэрт хамрагдсан ба төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсөв санхүү, бүртгэл тайлагналтай холбоотой зөрчил илрээгүй

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн албаны 2023,2024 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл хөтлөлт, шатахууны норм, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй зэрэг дараах зөрчил дутагдал илэрлээ,

Илрүүлэлт 1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр дахин үнэлэх буюу бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ аваагүй 3,300.0 мянган төгрөгийг тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх”, 5.1.5 дах “хэмжигдэхүйц байх”, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн

бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон ОНӨГ-ын шийдвэрээр дахин үнэлэх буюу бүртгэлээс хасаж тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Цалингийн зардлын төсвийг үндэслэлгүй төлөвлөж цалингийн урамшуулалын зардлыг зардлын эдийн засгийн ангиллаар батлаагүй, үндсэн цалин нэмэгдэл цалингийн зардлаар баталснаар төсвийн хуваарь төлөвлөгдөөгүй 4,272.4 мянган төгрөгийн зардлын гүйцэтгэл тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 22 дугаар 22.1 дэх “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, 1 дүгээр зүйлийн 41.2.2 дах “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “Эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын эдийн засгийн ангиллыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу үнэн зөв төлөвлөж батлуулах албан шаардлага хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн албаны 2023, 2024 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд ” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн албаны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **7,572.4** мянган төгрөгийн **2** зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 4,272.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,300.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн

гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус Рашаант тосгоны Захирагчийн албаны Захирагч, нягтлан бодогч нарт танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг тус сумын Рашаант тосгоны Захирагчийн албаны дарга, нягтлан бодогч нарт даалгав.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:

РАШААНТ ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЛБАНЫ ЗАХИРАГЧ

Б.ОТГОНБАЯР



НЯГТЛАН БОДОГЧ

Handwritten signature of L. Baasanсүрэн

Л.БААСАНСҮРЭН